

БАДАМТАРЫН БАЛДОО (1925-2003)

Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн, Шинжлэх ухааны Академийн жинхэнэ гишүүн, дипломатч Бадамтарын Балдоо удтал хүндээр өвчилж байгаад 2003 оны хоёрдугаар сарын 22-ны өдөр таалал төгсч, Монголын шинжлэх ухаанд том гарз тохиолоо.

Бодонгууд-Хоонхон овогт Бадамтарын Балдоо 1925 онд төрж, 1947 онд МУИС, 1959 онд Москва дахь Нийгмийн ухааны Академийг тус тус дүүргэжээ.

1947-1976 онуудад МАХН-ын төв Хороонд лектор, ухуулгын тасгийн дарга, «Энхтайван социализмын асуудал» сэтгүүлийн монгол редакц, Намын түүхийн Институтийн орчуулгын тасаг, МУИС-ийн философийн тэнхим, «Үнэн» сонины хэлтэс зэрэг газарт ерөнхий эрхлэгч, эрхлэгч, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институтийн захирал, 1976-1984 онд БНАСАУ, БНЭУ (Балба, Бангладеш, Шри-Ланка), БНУАУ (Австри)-д БНМАУ-ын Элчин сайд, 1984-1990 онд Нийгмийн ухааны Институтийн захирал, 1991 оноос өдгөөг хүртэл ШУА-ийн Зүүн хойд Ази судлалын төв болон Олон улсын судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажиллаж байв.

Тэрээр ухамсарт амьдралаа 30 гаруй жил шинжлэх ухааны байгууллагад зориулж МАХН-ын товч түүх зохиох, редакторлах, хэвлэн нийтлэхэд оролцож, Монгол дахь соёлын байгуулалт, улс төр судлал, нийгмийн хөгжил, дэвшил, Богд хаант Монгол Улс ба Орос, Хятадын бодлого, Зүүн хойд Азид регионализмын дэлгэрэлт, бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграцийн хөгжил, түүнд Монгол Улсын оролцоо зэрэг судалгааны өргөн сэдвээр ажиллаж, «Монгол Улс ба Зүүн хойд Ази» хамтын бүтээлийг редакторлан «Монгол Улсын гадаад харилцаа» зэрэг судалгааны томоохон бүтээл туурвисан нэрт эрдэмтэн байлаа.

Б.Балдоо 1960 онд философийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж, 1975 онд ШУА-ийн сурвалжлагч гишүүн, 1991 онд жинхэнэ гишүүнээр сонгогдож, Сайд нарын

Зөвлөлийн дэргэдэх эрдмийн зэрэг цол олгох дээд комиссын гишүүнээр ажиллажбайв.

Түүний шургуу хөдөлмөр, бүтээлч үйлсийг төр, засаг өндөр үнэлэн Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одонгоор хоёр удаа шагнаж, БНМАУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин цол олгожээ. Мөн БНУАУ-ын Тугийн одонгоор шагнагдсан байна.

Тэрээр МАХН-ын Төв Хорооны гишүүн, Монголын биеийн тамир спортын эвлэл, Монголын үндэсний олимпийн хорооны гишүүн, Монголын волейболын холбооны даргын сонгуульт ажил гүйцэтгэж байв.

Талийгаачийн төлөв даруу, ухаалаг, шударга, нөхөрсөг, хөдөлмөрч бүтээлч сайхан зан чанар, ажил амьдралын арвин туршлага, эрдмийн их өв бид бүхний сэтгэл зүрхэнд хоногшин үлдэж, үеийн үед уламжлагдан хадгалагдах болно.

Н.Багабанди, С.Төмөр-Очир, Н.Энхбаяр, Т.Ганди, Б.Чадраа, Ч.Авдай, Ө.Энхтүвшин, А.Цанжид, Л.Эрдэнэчулуун, Б.Эрдэнэсүрэн, Б.Мишигжав, Д.Идэвхитэн, Б.Энхтүвшин, Т.Галбаатар, Д.Рэгдэл, Ц.Ганцог, Ч.Далай, Б.Лхамсүрэн, Ш.Чунаг, О.Адъяа, Л.Хайсандай, Г.Чулуунбаатар, Д.Батжаргал, О.Эрдэнэчимэг, Д.Шүрхүү, С.Дамдинсүрэн, О.Батсайхан, Б.Сумъяа, Б.Лигдэн, Ш.Магван, М.Дамбадорж, Н.Тогоо